

# УЛСЫН ШАЛГАЛТ - 2023

## МОНГОЛ ХЭЛ

### V АНГИ

Аймаг/дүүрэг: .....

Сум: .....

Сургууль: .....

Анги: ..... Бүлэг: .....

Овог: .....

Нэр: .....

#### САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

- Эхийг анхааралтай уншаад, даалгавруудыг гүйцэтгээрэй.
- Шалгалт 60 минутад үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй.

## Мөчирхөн

Өнөөдөр нар эзсэн таатай сайхан өдөр байлаа. Болдоо цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалж явтал өөрөөс нь ялимгүй өндөр ургасан зулзаган мод түүний анхаарлыг татав.

Үгүй мөн гоё оо? Үүгээр чинь чавх хийе гэж бодов. Тэгээд тэр зулзаган модны нэг мөчрийг хугалан авчихлаа.

-За хүү минь яаж байгаа юм бэ? гэх дуунаар эргэн хартал цэцэрлэгч өвөө ирсэн байв. Болдоог хариу хэлэхийг ч хүлээсэнгүй:

-Чиний гар хөлийг гэмтээвэл өвдөх үү? гэж асуув

-Өвдөнө.

-Цус гарах уу?

-Гарна.

-Тэгвэл энэ модноос шүүс гарч байна уу?

-Тийм ээ Шүүс гарч байна.

-Энэ мод та хоёр яг адилхан балчир шүү дээ. Эргэн тойронд ургасан өндөр модыг үүний эх эцэг нь ч гэж бодож болно. Тэгэхээр хүүхдийнх нь нэг мөчрийг өвтгөчихжээ. Чи үүнээс хойш битгий ингэж байгаарай хэлээд, хөрс сийрүүлэх ажлаа хичээнгүйлэн хийж байв.

Болдоо тасалж авсан мөчрөө нэг хараад, зулзаган модоо нэг хараад хэсэг хугацаанд бодолд автав. Нээрээ л тусгүй юм болж дээ.

Өмнө нь гараа эсгэхэд ээж нь түүнийг самбайгаар боож эдгээснийг санаад, гэр лүүгээ харайлгалаа. Зулзган модны хугарсан мөчрийг нь ээж шигээ үлээж:

-Удахгүй эдгэнэ мөчирхөн минь. Битгий гомд гээд боов.

Болд мөчрөө өдөр болгон ирж хардаг ч мөчир эдгэрсэнгүй, ургасангүй. Бусад мөчрийнх нь навч бүгд дэлбээлж гүйцээд байхад боолттой мөчирхөн уйтгартай нь аргагүй хатаж ганджээ... Болдоо цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалж явахад урдын адил сайхан агаар, чийглэг уур амьсгал үгүй болсон мэт санагдаж байв. Модны салаа мөчир бүрийг хайрлан хамгаалах ёстойг маш сайн ойлгож ухаарлаа.

1. “Мөчрийн хатаж гандах болсон” учрыг эхийн эхлэл хэсгээс олж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

2. А. Эхийн үйл явдал ямар улиралд болж байна вэ? /1 оноо/

.....

.....

.....

.....

- Б. Хариултаа батлах жишээ өгүүлбэр хоёрыг эхээс олж бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

3. А. Цэцэрлэгч өвөөгийн **хийсэн үйл, хэлсэн үгийг** ялган бичээрэй. **/2 оноо/**

.....

.....

.....

.....

.....

Б. Цэцэрлэгч өвөөгийн хийсэн үйлийг зөв, буруу аль нь болохыг дүгнэж бичээрэй. **/2 оноо/**

.....

.....

.....

.....

4. Хүснэгтэд Болдоогийн зан чанарын өөрчлөлтийг дүгнэн бичээрэй.

Эхлэл хэсэгт ямар зан чанартай байсан бэ?	Төгсгөл хэсэгт ямар зан чанартай болсон бэ?
<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
<p>Яагаад өөрчлөгдөх болсон бэ?</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	

5. Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлэх өгүүлбэрийг олж бичээд, яагаад өгүүлбэрийг сонгосноо өөрийн үгээр тайлбарлаарай. **/3 оноо/**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

6. “Миний зурсан хамгийн гоё зураг” сэдвээр өөрт тохиолдсон явдлаа 100-120 үгэнд багтаан бичээрэй.

Бичихдээ:

- Эхлэлт хэсэгт – Үйл явдал өрнөсөн орчныг дүрслэн бичээрэй.
- Гол хэсэг – Өөрт тохиолдсон, болсон явдлыг бичих
- Төгсгөл хэсэгт – Өөрт тохиолдсон явдлаар дамжуулан бусдад ямар сургамжит санаа өгч болох вэ?

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

